



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 5/89


Хэрлэн сум

Н.Лхагвадоржийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”, Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Намжилын Лхагвадоржийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолоочоор 2022 оны 9 дүгээр сарын 05-аас эхлэн томилсугай.
2. Н.Лхагвадоржийн сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 569,585 (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав) төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож тус тус олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.
3. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Н.Лхагвадоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР